



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2022 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	3
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	9
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...9	
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	10
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	11
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	11
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	12
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	12
3.4 Зээлийн чанарын талаар.....	13
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	15
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	15
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	16
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	17
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	17
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	18
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	18
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	19
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	19
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	19
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	20
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	21
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	21
ДОЛОО.ДҮГНЭЛТ	22

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2022 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023.02.10


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 196 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 ХЗХ буюу 6.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 45.4 хувь буюу 89 ХЗХ орон нутагт, 54.6 хувь буюу 107 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/



ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй буурсан боловч санхүүгийн болон статистик үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 4 улирал дараалан хангаагүй, өөрийн хөрөнгөгүй, хоршоологчдын өмчгүй болж үйл ажиллагаа доголдсон ХЗХ-дын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой юм.

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 28 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 4 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг

түдгэлзүүлэх, 6 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 1 ХЗХ-нд салбар байгуулах зөвшөөрөл нэмж олгосон бөгөөд 21 ХЗХ-ны 185 сонгуульт гишүүн, 15 гүйцэтгэх захирал, 8 нягтлан бодогч, 2 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2018	2019	2020	2021	2022.IV
ХЗХ-дын тоо	279	261	249	209	196
Шинээр олгосон	18	17	14	-	7
Хүчингүй болгосон	29	35	26	40	20
Түдгэлзүүлсэн	19	10	23	12	13
Сэргээсэн	7	1	6	1	3
ТЗ-ийн хугацаа сунгасан	100	52	49	85	62

Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа



1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 196 ХЗХ-ны 762 ажилтан, 71,657 гишүүн /71,438 иргэн, 219 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 8 дүүрэгт 107 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 ХЗХ буюу 7.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 89 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймагт тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт




Тайлант улирлын байдлаар нийт 196 ХЗХ 61 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна.

1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,743 гишүүн буюу 5.0 хувиар буурч 71,657-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.3 хувь буюу 219 хуулийн этгээд, 53.3 хувь буюу 38,224 эмэгтэй гишүүн байна.

Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



НИЙТ ГИШҮҮД
71,657



Хуулийн этгээд
219




Хувь хүн
71,438



Эмэгтэй гишүүн
38,224

Нийт гишүүдийн 55.3 хувь буюу 39,626 гишүүн Улаанбаатар хотод бүртгэлтэй бол 44.7 хувь буюу 32,031 гишүүн орон нутагт бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч 2018-2021 оны 4 дүгээр улирлын байдлаар гишүүдийн тоо тогтмол өсч байсан бол тайлант хугацаанд 5.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүдийн 13.5 хувь буюу 5,336 гишүүн “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 49 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн тайлант улиралд “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн санхүүжилттэй 29 ХЗХ 11,466 гишүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.


Нийт 196 ХЗХ-ны 36.2 хувь буюу 71 ХЗХ 20-100 гишүүнтэй, 49.5 хувь буюу 97 ХЗХ 101-500 гишүүнтэй, 8.7 хувь буюу 17 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 5.6 хувь буюу 11 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	71	3,957	5.5%
101-500 гишүүнтэй	97	21,144	29.5%
501-1,000 гишүүнтэй	17	12,006	16.8%
1,001-ээс дээш гишүүнтэй	11	34,550	48.2%
Нийт	196	71,657	100.0%

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 11 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 48.2 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



- 20-100 гишүүнтэй
- 101-500 гишүүнтэй
- 501-1,000 гишүүнтэй
- 1,001-ээс дээш гишүүнтэй

1.4 Бодлого, зохицуулалтын орчин

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- АХБ-ны ТА-6883 MON: “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх төсөл”-ийн дэд хэсэг “Ногоон санхүүгийн хүртээмж, жендерийн тэгш байдлыг дэмжих төсөл”-ийг ХЗХ-ны зах зээлд 2022-2024 онд хэрэгжүүлэхээр дотоодын зөвлөх ажиллаж байна. ХЗХ-дын гишүүн эмэгтэй удирдлага бүхий БЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, ногоон санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгааг хийх бэлтгэл ажлыг хангасан.

Хууль, эрх зүйн орчин

- Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/156 тоот тушаалаар байгуулагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны заавар, дансны жагсаалт, аргачлал болон маягт батлах тухай” журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт төлөөлөл ажиллаж байна. Ажлын хэсгийн хуралд 2022.11.08-ны өдөр оролцож “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны нэгдсэн жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх аргачлал”-ын шинэчилсэн найруулгын төслийг танилцуулсан.
- Монголбанкны ерөнхийлөгчийн 2022 оны А-288 дугаар тушаалаар баталсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 18.1 дэх хэсэгт заасан харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг тогтоохтой холбогдсон үндэслэл бүхий суурь судалгаа хийх, санал дэвшүүлэх” ажлын хэсэгт ажиллаж, төлөвлөгөөний дагуу банкнаас

бусад санхүүгийн байгууллага дахь харилцах дансны хүүгийн нөлөөллийн талаар танилцуулга бэлтгэн 2022.11.25-ны өдөр ажлын хэсгийн ахлагчид хүргүүлсэн.

- Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын 2022 оны А/61 дүгээр тушаалаар Хадгаламж, зээлийн хоршооны мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 2022.12.01-ний өдөр хуралдаж мэдээлэл солилцсон бөгөөд холбогдох судалгааг хийхээр тогтсоны дагуу 2022.12.22-ны өдрөөс эхлэн ХЗХ-доос гишүүдийн хадгаламжийн судалгааг авсан.
- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулж МХЗХҮХ-оос санал авахаар 2022.11.02-ны өдөр хүргүүлсэн бол олон нийтээс санал авахаар 2022.12.08-ны өдөр Хорооны цахим хуудсанд байршуулсан. 2022 онд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулсан 49 ХЗХ-ны санхүүгийн болон удирдлагын чанарын үзүүлэлтүүдэд үндэслэн зайны үнэлгээний аргачлалыг туршиж эхлээд байна.
- Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн Хорооны 2022.12.09-ний өдрийн 687 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Мөн Хорооны 2022 оны 723 дугаар тогтоолоор нэр бүхий 54 ХЗХ, Хорооны даргын 2022 оны 543 дугаар тушаалаар нэр бүхий 9 ХЗХ-ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох тухай асуудлыг шийдвэрлэсэн.

- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Хорооны даргын 2022 оны 498 дугаар тушаалаар холбогдох дүрэм, журам, заавар зэргийг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд 3 дэд ажлын хэсэгт хуваагдаж, 5 журмын төсөл боловсруулахаар ажиллаж байна.

Хурал, семинар, уулзалт

- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг дунд үйлдвэрлэлийн газрын хамтарсан БЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөний дагуу 2022.10.13-ны өдөр Чингэлтэй дүүрэг, 2022.10.19-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн БЖДҮ

эрхлэгчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж "Банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллага" сэдвээр мэдээлэл өгсөн.

- АХБ-ны ТА-6883 MON: “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх төсөл”-ийн дэд хэсэг “Ногоон санхүүгийн хүртээмж, жендерийн тэгш байдлыг дэмжих төсөл”-ийг Монгол Улсад хэрэгжүүлэх хамтрагч байгууллага болох Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ТоС-ын холбооноос хамтран 2022.11.29-ний өдөр зохион байгуулсан төслийн эхлэлтийн хэлэлцүүлэгт оролцож Санхүүгийн зохицуулах хорооны хариуцан гүйцэтгэх ажлын талаар мэдээлэл өгсөн.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 196 ХЗХ-оос 2022 оны 4 дүгээр улирлын тайлангийн нэгтгэлд 6 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан.

2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 3: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	196	100.0%	107	54.6%	89	45.4%
Нийт гишүүдийн тоо	71,657	100.0%	39,626	55.3%	32,031	44.7%
Эрэгтэй	33,214	46.4%	16,864	50.8%	16,350	49.2%
Эмэгтэй	38,224	53.3%	22,609	59.1%	15,615	40.9%
Гишүүн хуулийн этгээд	219	0.3%	153	69.9%	66	30.1%
Гишүүдийн насжилт	71,438	100.0%	39,473	55.3%	31,965	44.7%
18-35 насны	19,680	27.6%	11,137	56.6%	8,543	43.4%
36-45 насны	21,001	29.4%	12,097	57.6%	8,904	42.4%
46-55 насны	17,453	24.4%	9,004	51.6%	8,449	48.4%
55-аас дээш	13,304	18.6%	7,235	54.4%	6,069	45.6%
Гишүүдийн боловсрол	71,438	100.0%	39,473	55.3%	31,965	44.7%
Дээд	30,894	43.2%	21,004	68.0%	9,890	32.0%
Тусгай дунд	12,823	18.0%	7,675	59.9%	5,148	40.1%
Бүрэн дунд	18,000	25.2%	9,078	50.4%	8,922	49.6%
Дунд	7,084	9.9%	1,561	22.0%	5,523	78.0%
Бага	2,637	3.7%	155	5.9%	2,482	94.1%
Нийт ажилтнуудын тоо	762	100.0%	402	52.8%	360	47.2%
Үүнээс: эмэгтэй	510	66.9%	287	56.3%	223	43.7%
Санхүүгийн програмтай	98	50.0%	42	21.4%	56	28.6%
Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	15	100.0%	11	73.3%	4	26.7%
Гүйлгээний тоо	349	100.0%	309	88.5%	40	11.5%
Гүйлгээний дүн /мян.төг/	40,049,376.97	100.0%	24,210,731.55	60.5%	15,838,645.42	39.5%
Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	0	0	0	0	0	0

Сэжигтэй гүйлгээний тоо	0	0	0	0	0	0
Сэжигтэй гүйлгээний дүн /мян.төг/	0	0	0	0	0	0

2022 оны 4 дүгээр улиралд нийт ХЗХ-дын 7.7 хувь буюу 15 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 40,049,376.97 мянган төгрөгийн 349 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 88.5 хувь буюу 24,210,731.55 мянган төгрөгийн гүйлгээг Улаанбаатар хотын 11 ХЗХ, 26.7 хувь буюу 15,838,645.42 мянган төгрөг бүхий 40 гүйлгээг орон нутгийн 4 ХЗХ мэдээлсэн байна. Тайлант улирлын байдлаар сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

ХЗХ-дын нийт гишүүдийн 57.0 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс харьцангуй залуу байна.

Нийт гишүүдийн 43.2 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын

гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 68.0 хувь нь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн насжилт, УБ, орон нутгаар





График 5: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар



Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	196	100.0%	107	54.6%	89	45.4%
Нийт зээлийн үлдэгдэл	210,229,235.80	100.0%	162,622,621.47	77.4%	47,606,614.33	22.6%
Нийт зээлдэгчийн тоо	32,424	100.0%	16,865	52.0%	15,559	48.0%
Иргэн	32,339	99.7%	16,795	99.6%	15,544	99.9%
Эмэгтэй	17,640	54.4%	9,331	55.3%	8,309	53.4%
Хуулийн этгээд	85	0.3%	70	0.4%	15	0.1%
Зээлдэгчдийн насжилт	32,339	100.0%	16,795	51.9%	15,544	48.1%
18-35 насны	8,890	27.5%	5,121	30.5%	3,769	24.3%
36-45 насны	9,888	30.6%	5,173	30.8%	4,715	30.3%
46-55 насны	9,436	29.2%	5,072	30.2%	4,364	28.1%
55-аас дээш	4,125	12.7%	1,429	8.5%	2,696	17.3%
Зээлдэгчдийн боловсрол	32,339	100.0%	16,795	51.9%	15,544	48.1%
Дээд	12,420	38.4%	7,496	44.6%	4,924	31.7%
Тусгай дунд	6,371	19.7%	3,852	23.0%	2,519	16.2%
Бүрэн дунд	7,504	23.2%	2,860	17.0%	4,644	29.9%
Дунд	4,631	14.3%	2,522	15.0%	2,109	13.5%
Бага	1,413	4.4%	65	0.4%	1,348	8.7%

Тайлант улиралд ХЗХ-д 32,424 зээлдэгчийн 210,229,235.80 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 52.0 хувь буюу 16,865 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 77.4 хувь буюу 162,622,621.47 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 48.0 хувь буюу 15,559 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 22.6 хувь буюу

47,606,614.33 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.7 хувь буюу 32,339 хувь хүн (54.4 хувь буюу 17,640 нь эмэгтэй), 0.3 хувь буюу 85 хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 6,483.75 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 9,642.61 мянган төгрөг, орон нутагт 3,059.75 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	196	100.0%	107	54.6%	89	45.4%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	187,500,577.22	100.0%	148,965,151.87	79.4%	38,535,425.35	20.6%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	38,540	100.0%	19,927	51.7%	18,613	48.3%
Эмэгтэй	21,881	56.8%	10,916	54.8%	10,965	58.9%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	2,814,882.69	1.5%	2,296,658.78	1.5%	518,223.91	1.3%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	3,925	10.2%	2,971	14.9%	954	5.1%
Иргэн	3,905	10.1%	2,953	14.8%	952	5.1%
Хуулийн этгээд	20	0.1%	18	0.1%	2	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	184,685,694.53	98.5%	146,668,493.08	98.5%	38,017,201.45	98.7%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	34,615	89.8%	16,956	85.1%	17,659	94.9%
Иргэн	34,569	89.7%	16,941	85.0%	17,628	94.7%
Хуулийн этгээд	46	0.1%	15	0.1%	31	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	37,931	100.0%	19,356	100.0%	18,575	100.0%
18-35 насны	13,150	34.7%	8,153	42.1%	4,997	26.9%
36-45 насны	10,246	27.0%	4,908	25.4%	5,338	28.7%
46-55 насны	8,302	21.9%	3,662	18.9%	4,640	25.0%
55-аас дээш	6,233	16.4%	2,633	13.6%	3,600	19.4%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	37,931	100.0%	19,356	100.0%	18,575	100.0%
Дээд	17,653	46.6%	12,131	62.7%	5,522	29.7%
Тусгай дунд	4,846	12.8%	2,046	10.6%	2,800	15.1%
Бүрэн дунд	8,509	22.4%	3,490	18.0%	5,019	27.0%
Дунд	4,220	11.1%	970	5.0%	3,250	17.5%
Бага	2,703	7.1%	719	3.7%	1,984	10.7%

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 38,540 хадгаламж эзэмшигчийн 187,500,577.22 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 51.7 хувь буюу 19,927 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 79.4 хувь буюу 148,965,151.87 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 48.3 хувь буюу 18,613 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 20.6 хувь буюу 38,535,425.35 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 1.5 хувийг хугацаагүй, 98.5 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 38,474 нь хувь хүн (56.8 хувь буюу 21,881 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 66 нь хуулийн этгээд байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 4,865.09 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,475.54 мянган төгрөг, орон нутагт 2,070.35 мянган төгрөг байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 267,715,699.75 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувь буюу 23,481,763.70 мянган төгрөгөөр буурч банкны зах зээлийн 0.6 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 1.5 хувь буюу 3,192,232.73 мянган төгрөгөөр,

нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 7.9 хувь буюу 16,085,333.96 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 1.7 хувь буюу 978,679.18 мянган төгрөг, нийт зарлага 0.2 хувь буюу 110,975.05 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт цэвэр орлого 8.1 хувь буюу 867,704.13 мянган төгрөгөөр өсч 11,616,373.13 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны IV улирал	2022 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	291,197,433.45	267,715,669.75		
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.6%	-23,481,763.70	-8.1%
Нийт зээл	213,421,468.53	210,229,235.80		
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	0.9%	-3,192,232.73	-1.5%
Нийт чанаргүй зээл	7,393,064.38	7,046,472.75		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.5%	3.4%	-0.1%	-3.2%
Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.4%	0.0%	-2.1%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	203,585,911.18	187,500,577.22		
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.1%	-16,085,333.96	-7.9%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	25,362,675.29	25,902,489.10		
Нийт хоршоологчдын өмч	38,365,311.58	33,680,259.92		
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	8,482,007.77	5,570,416.63		
Нийт орлого	57,974,378.53	58,953,057.71	978,679.18	1.7%
Нийт зарлага	47,225,709.53	47,336,684.58	110,975.05	0.2%
Цэвэр орлого, алдагдал	10,748,669.00	11,616,373.13		
			867,704.13	8.1%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 107 ХЗХ-ны нийт хөрөнгө 209,247,734.43 мянган төгрөг нь зах зээлийн 78.2 хувь, нийт зээл 162,622,621.47 мянган төгрөг нь зах зээлийн 77.4 хувь, нийт хадгаламж 148,965,151.87 мянган төгрөг нь зах зээлийн 79.4 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.9 хувь буюу 1,069,103.97 мянган төгрөгөөр буурч 5,668,742.66 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.5 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 34.1 хувь буюу 2,865,491.15 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн

үеэс 4.1 хувь буюу 1,848,068.04 мянган төгрөгөөр, нийт зарлага 6.0 хувь буюу 2,257,489.39 мянган төгрөгөөр буурч, нийт цэвэр орлого 5.2 хувь буюу 409,421.35 мянган төгрөгөөр нэмэгдэж 8,286,903.05 төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 48.6 хувь буюу 52 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны IV улирал	2022 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	239,725,926.52	209,247,734.43	-30,478,192.09	-12.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	82.3%	78.2%	-4.2%	-5.1%
Нийт зээл	171,617,487.98	162,622,621.47	-8,994,866.51	-5.2%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	80.4%	77.4%	-3.1%	-3.8%
Нийт чанаргүй зээл	6,737,846.63	5,668,742.66	-1,069,103.97	-15.9%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	91.1%	80.4%	-10.7%	-11.7%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.9%	3.5%	-0.4%	-11.2%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	168,924,083.46	148,965,151.87	-19,958,931.60	-11.8%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	83.0%	79.4%	-3.5%	-4.3%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	19,408,701.82	19,399,941.56	-8,760.26	0.0%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	76.5%	74.9%	-1.6%	-2.1%
Нийт хоршоологчдын өмч	30,617,867.40	24,126,395.50	-6,491,471.90	-21.2%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	79.8%	71.6%	-8.2%	-10.2%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	8,405,907.77	5,540,416.63	-2,865,491.15	-34.1%
Нийт орлого	45,533,861.13	43,685,793.09	-1,848,068.04	-4.1%
Нийт зарлага	37,656,379.44	35,398,890.04	-2,257,489.39	-6.0%
Цэвэр орлого, алдагдал	7,877,481.70	8,286,903.05	409,421.35	5.2%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 89 ХЗХ-ны нийт хөрөнгө 58,467,935.32 мянган төгрөг нь зах зээлийн 21.8 хувь, нийт зээлийн үлдэгдэл 47,606,614.33 мянган төгрөг нь зах зээлийн 22.6 хувь, нийт хадгаламж 38,535,425.35 мянган төгрөг нь зах зээлийн 20.6 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 22.7 хувь буюу 2,826,747.22 мянган төгрөг, нийт зарлага 24.8 хувь буюу 2,368,464.45 мянган төгрөгөөр тус тус өсч, цэвэр орлого 16.0

хувь буюу 458,282.77 мянган төгрөгөөр нэмэгдэж 3,329,470.08 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 48.3 хувь буюу 43 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны IV улирал	2022 оны IV улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	51,471,506.93	58,467,935.32	6,996,428.39	13.6%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	17.7%	21.8%	4.2%	23.6%
Нийт зээл	41,803,980.55	47,606,614.33	5,802,633.78	13.9%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	19.6%	22.6%	3.1%	15.6%
Нийт чанаргүй зээл	655,217.75	1,377,730.09	722,512.34	110.3%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	8.9%	19.6%	10.7%	120.6%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	1.6%	0.8%	-0.7%	-45.9%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	34,661,827.71	38,535,425.35	3,873,597.64	11.2%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	17.0%	20.6%	3.5%	20.7%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	5,953,973.47	6,502,547.54	548,574.07	9.2%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	23.5%	25.1%	1.6%	6.9%
Нийт хоршоологчдын өмч	7,747,444.19	9,553,864.42	1,806,420.24	23.3%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	20.2%	28.4%	8.2%	40.5%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	76,100.00	30,000.00	-46,100.00	-60.6%
Нийт орлого	12,440,517.40	15,267,264.62	2,826,747.22	22.7%
Нийт зарлага	9,569,330.09	11,937,794.54	2,368,464.45	24.8%
Цэвэр орлого, алдагдал	2,871,187.30	3,329,470.08	458,282.77	16.0%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2021 оны IV улирал		2022 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	280,082,405.11	96.2%	263,615,793.41	98.5%	-16,466,611.71	-5.9%
Мөнгөн хөрөнгө	61,336,408.78	21.1%	39,998,061.49	14.9%	-21,338,347.29	-34.8%
Бэлэн мөнгө	3,815,314.01	1.3%	5,389,574.22	2.0%	1,574,260.21	41.3%
Банкинд байршуулсан харилцах	13,265,916.99	4.6%	13,877,483.04	5.2%	611,566.05	4.6%
Банкинд байршуулсан хадгаламж	44,255,177.77	15.2%	20,731,004.23	7.7%	-23,524,173.54	-53.2%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	150,000.00	0.0%	650,000.00	0.2%	500,000.00	333.3%
Арилжааны үнэт цаас	150,000.00	0.0%	650,000.00	0.2%	500,000.00	333.3%
Зээл /цэврээр/	207,849,100.05	71.4%	204,972,547.37	76.6%	-2,876,552.68	-1.4%
Нийт зээл	213,421,468.53	73.3%	210,229,235.80	78.5%	-3,192,232.73	-1.5%
Хэвийн зээл	202,122,837.16	69.4%	197,245,086.74	73.7%	-4,877,750.42	-2.4%
Хугацаа хэтэрсэн зээл	3,905,566.98	1.3%	5,937,676.31	2.2%	2,032,109.33	52.0%
Чанаргүй зээл	7,393,064.38	2.5%	7,046,472.75	2.6%	-346,591.64	-4.7%
(Зээлийн эрсдэлийн сан)	5,572,368.48	1.9%	5,256,688.43	1.9%	-315,680.05	-5.7%
Авлага	9,062,588.18	3.1%	15,800,561.53	5.9%	6,737,973.35	74.3%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	740,635.24	0.3%	7,639,762.51	2.9%	6,899,127.26	931.5%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,321,952.94	2.8%	8,160,799.02	3.0%	-161,153.91	-1.9%
Бусад эргэлтийн хөрөнгө	917,997.81	0.3%	1,286,006.62	0.5%	368,008.81	40.1%
Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/	766,310.29	0.3%	908,616.39	0.4%	142,306.10	18.6%
Өмчлөх бусад хөрөнгө	804,623.61	0.3%	946,929.71	0.4%	142,306.10	17.7%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	38,313.32	0.0%	38,313.32	0.0%	0.00	0.0%
Эргэлтийн бус хөрөнгө	11,115,028.34	3.8%	4,099,876.35	1.5%	-7,015,151.99	-63.1%
Үндсэн хөрөнгө /цэвр/	3,884,855.05	1.3%	3,923,987.47	1.5%	39,132.43	1.0%
Үндсэн хөрөнгө	5,874,613.06	2.0%	6,165,274.45	2.3%	290,661.38	4.9%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,989,758.02	0.7%	2,241,286.97	0.8%	251,528.96	12.6%
Биет бус хөрөнгө	7,214,685.50	2.5%	160,386.18	0.1%	-7,054,299.31	-97.8%
Биет бус хөрөнгө	7,330,374.39	2.5%	314,658.39	0.1%	-7,015,716.00	-95.7%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	115,688.89	0.0%	154,272.21	0.0%	38,583.31	33.4%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,487.79	0.0%	15,502.69	0.0%	14.89668	0.1%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,487.79	0.0%	15,502.69	0.0%	14.89668	0.1%
Хөрөнгийн дүн	291,197,433.45	100.0%	267,715,669.75	100.0%	-23,481,763.70	-8.1%

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/




2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 267,715,669.75 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувь буюу 23,481,763.70 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 98.5 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.5 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 14.9 хувийг, цэвр зээл 76.6 хувийг тус тус эзэлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.5 хувь буюу 3,192,232.73 мянган төгрөгөөр буурч 210,229,235.80 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,256,688.43 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 204,972,547.37 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52.0 хувь буюу 2,032,109.33 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2018-2021 онуудад тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо буурсан ч

хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

График 6: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/




3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 155,563,374.42 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 58.3 хувийг, гишүүдийн тоо 21,430 байгаа нь нийт гишүүдийн 29.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	154,352,790.67	57.7%	20,524	28.7%
2	1,000,000.0 -10,000,000.0	25	77,951,702.99	29.1%	23,452	32.7%
3	500,000.0-1,000,000.0	22	15,451,437.86	5.8%	8,912	12.4%
4	100,000.0-500,000.0	73	15,755,345.44	5.9%	13,066	18.2%
5	50,000.0-100,000.0	47	3,511,800.47	1.3%	4,298	6.0%
6	10,000.0-50,000.0	21	668,055.98	0.2%	1,279	1.8%
7	10,000.0 хүртэл	4	24,536.34	0.01%	126	0.2%
Нийт дүн		196	267,715,669.75	100.0%	71,657	100.0%



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 210,229,235.80 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 78.5 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 204,972,547.37 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 76.6 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.3 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 22 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 84.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	22	176,776,525.51	84.1%
2	500,000.0-1,000,000.0	19	13,750,909.36	6.5%
3	100,000.0-500,000.0	66	15,167,722.49	7.2%
4	50,000.0-100,000.0	45	3,296,175.06	1.6%
5	10,000.0-50,000.0	38	1,219,731.89	0.6%
6	10,000.0 хүртэл	5	18,171.49	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	1	-	-
Нийт дүн		196	210,229,235.80	100%

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	32,424	100.0%	210,229,235.80	100.0%
Хэвийн	30,069	92.7%	197,245,086.74	93.8%
Хугацаа хэтэрсэн	1,064	3.3%	5,937,676.31	2.8%
Чанаргүй	1,291	4.0%	7,046,472.75	3.4%
<i>Хэвийн бус</i>	386	29.9%	1,862,594.31	26.4%
<i>Эргэлзээтэй</i>	423	32.8%	1,527,142.66	21.7%
<i>Муу</i>	482	37.3%	3,656,735.78	51.9%

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 93.8 хувь буюу 197,245,086.74 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.8 хувь буюу 5,937,676.31 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.4 хувь буюу 7,046,472.75 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 12,984,149.06 мянган төгрөгийн үлдэгдэлд 40.5 хувь буюу 5,256,688.43 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.7 хувийг хэвийн, 3.3 хувийг хугацаа хэтэрсэн, 4.0 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,291 зээлдэгчийн 7,046,472.75 мянган төгрөгийн үлдэгдлийн 26.4 хувийг хэвийн бус, 21.7 хувийг

эргэлзээтэй, 51.9 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

График 7: Зээлийн чанар



Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр буурч 93.8 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 1.0 пунктээр нэмэгдэж 2.8 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.1 пунктээр буурч 3.4 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/


Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт	162,622,621.47	100.0%	77.4%	47,606,614.33	100.0%	22.6%
Хэвийн	152,372,354.69	93.7%	77.3%	44,872,732.06	94.3%	22.7%
Хугацаа хэтэрсэн	4,581,524.12	2.8%	77.2%	1,356,152.19	2.8%	22.8%
Чанаргүй	5,668,742.66	3.5%	80.4%	1,377,730.09	2.9%	19.6%
<i>Хэвийн бус</i>	1,198,207.92	21.1%	64.3%	664,386.40	48.2%	35.7%
<i>Эргэлзээтэй</i>	1,150,657.41	20.3%	75.3%	376,485.25	27.3%	24.7%
<i>Муу</i>	3,319,877.34	58.6%	90.8%	336,858.44	24.5%	9.2%

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал ХЗХ-ны зах зээлийн нийт зээлийн 77.4 хувь буюу 162,622,621.47 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-д, 22.6 хувь буюу 47,606,614.33 мянган

төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 93.7 хувь буюу 152,372,354.69 мянган төгрөгийг хэвийн, 2.8 хувь буюу 4,581,524.12 мянган

төгрөгийг хугацаа хэтэрсэн, 3.5 хувь буюу 5,668,742.66 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 58.6 хувь буюу 3,319,877.34 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд зах зээлийн нийт муу зээлийн 90.8 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 94.3 хувь буюу 44,872,732.06 мянган төгрөгийг хэвийн, 2.8 хувь буюу 1,356,152.19 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 2.9 хувь буюу 1,377,730.09 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

График 8: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Хүснэгт 14: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6,912,644.11	13,813,429.91	12,047,147.53	8,678,926.49	4.1%
2	Уул уурхай, олборлолт	2,111,077.09	2,317,366.89	2,511,248.72	1,917,195.26	0.9%
3	Боловсруулах үйлдвэрлэл	1,601,288.86	2,830,623.01	2,257,689.19	2,174,222.68	1.1%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	693,829.52	1,205,340.27	1,203,904.40	695,265.40	0.3%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	112,319.14	359,047.45	321,602.88	149,763.71	0.1%
6	Барилга	7,152,705.27	9,474,765.61	8,941,610.21	7,685,860.66	3.7%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	14,564,082.77	30,954,005.29	27,798,559.00	17,719,529.07	8.4%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	2,941,349.65	4,444,153.10	4,162,927.50	3,222,575.25	1.5%
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2,354,499.73	4,579,275.24	3,343,239.60	3,590,535.36	1.7%
10	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	4,795,775.63	5,291,345.17	4,888,556.82	5,198,563.99	2.5%
11	Мэдээлэл холбоо	3,879,440.71	726,830.15	577,594.86	4,028,676.00	1.9%
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	15,110,427.63	14,196,479.64	10,308,382.78	18,998,524.49	9.0%
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,944,192.28	3,459,847.32	3,211,568.42	2,192,471.17	1.0%
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	371,720.67	849,320.00	604,039.85	617,000.81	0.3%
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	208,354.54	946,987.38	788,903.98	366,437.94	0.2%
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.00	52,500.00	13,871.11	38,628.89	0.0%
17	Боловсрол	1,217,635.94	2,896,844.75	2,627,627.32	1,486,853.38	0.7%
18	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	1,083,395.31	1,348,435.97	1,502,216.95	929,614.33	0.5%
19	Бусад	145,055,126.08	274,307,818.54	288,824,353.69	130,538,590.92	62.1%
Үүнээс: Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл		18,365,559.53	104,471,517.48	103,615,291.85	19,221,785.17	9.1%
НИЙТ		212,109,864.93	374,054,415.68	375,935,044.81	210,229,235.80	100.0%

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д нийт 374,054,415.68 мянган төгрөгийн зээл олгож, 375,935,044.81 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж 210,229,235.80 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг зээлийн бүтээгдэхүүнээр нь ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 62.1 хувь буюу 130,538,590.92 мянган төгрөгийг бусад, 9.0 хувь буюу 18,998,524.49 мянган төгрөгийг санхүүгийн болон даатгалын үйл

ажиллагаа, 8.4 хувь буюу 17,719,529.07 мянган төгрөгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 4.1 хувь буюу 8,678,926.49 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 3.7 хувь буюу 7,685,860.66 мянган төгрөгийг барилгын зориулалтаар тус тус авсан байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 9.1 хувь буюу 19,221,785.17 мянган төгрөгийг хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл эзэлж байна.

ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар


Хүснэгт 15: ХЗХ-дын эх үүсвэрийн бүтэц (мянган төгрөгөөр)

ЭХ ҮҮСВЭР	2021 оны IV улирал		2022 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Өр төлбөр	227,301,079.98	78.1%	207,939,351.05	77.7%	-19,361,728.93	-8.5%
Хадгаламж	203,585,911.18	69.9%	187,500,577.22	70.0%	-16,085,333.96	-7.9%
Хугацаагүй	5,333,264.16	1.8%	2,814,882.69	1.1%	-2,518,381.47	-47.2%
Хугацаатай	198,252,647.02	68.1%	184,685,694.53	69.0%	-13,566,952.48	-6.8%
Богино хугацаат зээл	6,386,596.17	2.2%	2,608,334.25	1.0%	-3,778,261.92	-59.2%
Бусад богино хугацаат өр төлбөр	15,108,609.35	5.2%	14,696,806.98	5.5%	-411,802.36	-2.7%
Урт хугацаат өр төлбөр	2,219,963.29	0.8%	3,133,632.60	1.2%	913,669.31	41.2%
Өөрийн хөрөнгө	63,896,353.47	21.9%	59,776,318.70	22.3%	-4,120,034.77	-6.4%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	25,362,675.29	8.7%	25,902,489.10	9.6%	539,813.81	2.1%
Гишүүний оруулсан хувь хөрөнгө	25,242,566.57	8.7%	25,730,000.41	9.6%	487,433.84	1.9%
Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө	120,108.71	0.0%	172,488.69	0.0%	52,379.97	43.6%
Дахин үнэлгээний нэмэгдэл	168,366.60	0.0%	193,569.68	0.1%	25,203.08	15.0%
Хоршоологчдын өмч	38,365,311.58	13.2%	33,680,259.92	12.6%	-4,685,051.66	-12.2%
Нөөцийн сан	9,540,672.69	3.3%	10,871,044.69	4.1%	1,330,372.00	13.9%
Хандив, тусламж	326,332.53	0.1%	323,620.92	0.1%	-2,711.61	-0.8%
Хадгаламж, хамгаалалтын сан	2,276,836.70	0.8%	2,594,346.90	1.0%	317,510.20	13.9%
Нийгмийн хөгжлийн сан	833,124.19	0.3%	950,753.21	0.3%	117,629.01	14.1%
Тогтворжилтын сан	2,220,780.46	0.8%	2,645,020.16	1.0%	424,239.70	19.1%
Бусад сангууд	1,390,162.11	0.5%	1,645,092.03	0.6%	254,929.93	18.3%
Хуримтлагдсан орлого /алдагдал/	21,777,402.90	7.5%	14,650,382.01	5.5%	-7,127,020.89	-32.7%
Тайлангийн үеийн цэвэр орлого	10,748,669.00	3.7%	11,616,373.13	4.3%	867,704.13	8.1%
Өмнөх үеийн цэвэр орлого	11,028,733.90	3.8%	3,034,008.88	1.1%	-7,994,725.02	-72.5%
Нийт өр төлбөр ба өөрийн	291,197,433.45	100.0%	267,715,669.75	100.0%	-23,481,763.70	-8.1%

Зах зээлийн нийт өр төлбөр 207,939,351.05 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувь буюу 19,361,728.39 мянган төгрөгөөр, өөрийн хөрөнгө 59,776,318.70 мянган төгрөг нь 6.4 хувь

буюу 4,120,034.77 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн бүтцийн 77.7 хувийг өр төлбөр, 22.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

График 9: Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламж, хоршоологчдын өмч, гишүүдийн хувь хөрөнгийн дүн 2018 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 5 жилийн

хугацаанд 10.3-87.6 хувь хүртэл нэмэгдсэн байна. Харин бусад өр төлбөрийн дүн нийт 18.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

ХЗХ-ны зах зээлийн татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 187,500,577.22 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 70.0 хувийг эзэлж байна. Нийт хадгаламжийн 98.5 хувийг хугацаатай хадгаламж, 1.5 хувийг хугацаагүй хадгаламж тус тус бүрдүүлж байна.

байна. Тайлант улиралд 4 ХЗХ хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 16: ХЗХ-дын хадгаламж, интервалаар /мянган төгрөгөөр/


№	Хадгаламжийн хэмжээ	ХЗХ -д	Хадгаламжийн дүн	Эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	4	115,018,292.39	61.4%
2	1,000,000.0-10,000,000.0	16	46,933,259.05	25.0%
3	500,000.0-1,000,000.0	13	9,406,859.56	5.0%
4	100,000.0-500,000.0	51	12,413,397.57	6.6%
5	50,000.0-100,000.0	26	1,972,352.69	1.1%
6	10,000.0-50,000.0	62	1,658,052.66	0.9%
7	5,000.0-10,000.0	8	64,355.00	0.0%
8	5,000.0 хүртэл	12	34,008.29	0.0%
9	Хадгаламжгүй	4	-	-
Нийт дүн		196	187,500,577.22	100.0%

Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын 1.2 хувь байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн дүнгээр 10 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжтай 4 ХЗХ-ны хадгаламж нийт ХЗХ-дын хадгаламжийн дүнгийн 61.4 хувийг эзэлж

ХЗХ-ны зах зээлийн нийт хадгаламжийн хэмжээ сүүлийн 5 жилд дунджаар 6.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 10: ХЗХ-ны зах зээлийн хадгаламжийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар

Хүснэгт 17: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц (мянган төгрөгөөр)

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	2021 оны IV улирал		2022 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Богино хугацаат зээл	6,386,596.17	74.2%	2,608,334.25	45.4%	-3,778,261.92	-59.2%
Банкнаас авсан зээл	4,287,210.70	49.8%	717,000.00	12.5%	-3,570,210.70	-83.3%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	523,000.00	6.1%	522,000.00	9.1%	-1,000.00	-0.2%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	1,576,385.47	18.3%	1,369,334.25	23.8%	-207,051.22	-13.1%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	-
Урт хугацаат өр төлбөр	2,219,963.29	25.8%	3,133,632.60	54.6%	913,669.31	41.2%
Банкнаас авсан зээл	16,100.00	0.2%	1,999,998.04	34.8%	1,983,898.04	12322.3%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	-	0.0%	12,283.65	0.2%	12,283.65	100.0%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	2,079,311.61	24.2%	949,800.69	16.6%	-1,129,510.92	-54.3%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	104,558.28	1.8%	-	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	124,551.68	1.4%	66,991.94	1.2%	-57,559.74	-46.2%
Нийт дүн	8,606,559.45	100.0%	5,741,966.85	100.0%	-2,864,592.61	-33.3%

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын бусдаас авсан зээлийн үлдэгдэл 5,741,966.85 мянган төгрөг байгаа нь зах зээлийн нийт хөрөнгийн 2.1 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.3 хувь буюу 2,864,592.61 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант улиралд бусдаас авсан нийт зээлийн 45.4 хувийг богино хугацаат зээл, 54.6 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус бүрдүүлж байна.

Богино хугацаат зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 59.2 хувь буюу 3,778,261.92 мянган төгрөгөөр буурсан бол урт хугацаат өр төлбөр 41.2 хувь буюу 913,669.31 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн санхүүжилттэй ХЗХ-дын зээлийн үлдэгдэл 2,444,718.51 мянган төгрөг байна.

Хүснэгт 18: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц, хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	Нийт		УБ		Орон нутаг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Банкнаас авсан зээл	2,716,998.04	47.3%	2,716,998.04	47.8%	0.00	0.0%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	534,283.65	9.3%	524,283.65	9.2%	10,000.00	16.6%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	2,319,134.93	40.4%	2,299,134.93	40.5%	20,000.00	33.1%
Тогтворжилтын сангийн туслалцаа	104,558.28	1.8%	74,558.28	1.3%	30,000.00	49.7%
Хойшлогдсон татварын өр төлбөр	66,991.94	1.2%	66,621.37	1.2%	370.57	0.6%
Нийт дүн	5,741,966.85	100.0%	5,681,596.28	100.0%	60,370.57	100.0%

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд банкнаас авсан зээл 47.3 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 9.3 хувь, төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 40.4

хувь, тогтворжилтын сангийн туслалцаа 1.8 хувь, хойшлогдсон татварын өр төлбөр 1.2 хувийг тус тус эзэлж байна.

4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар

Хүснэгт 19: ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөрийн бүтэц /мянган төгрөгөөр/

БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2021 оны IV улирал		2022 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Цалингийн өглөг	129,777.27	0.9%	117,772.95	0.8%	-12,004.32	-9.2%

Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	1,252,328.18	8.3%	1,178,133.34	8.0%	-74,194.84	-5.9%
Ногдол ашгийн өглөг	209,574.89	1.4%	217,569.47	1.5%	7,994.58	3.8%
Санхүүгийн түрээсийн өглөг	16,281.84	0.1%	26,766.03	0.2%	10,484.18	64.4%
Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	95.36	0.0%	0.00	0.0%	-95.36	0.0%
Урьдчилж орсон орлого	87,546.21	0.6%	86,228.08	0.6%	-1,318.13	-1.5%
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	12,046,465.92	79.7%	11,886,035.20	80.9%	-160,430.72	-1.3%
Салбар хоорондын тооцоогоорх өглөг	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%
Бусад богино хугацаат өглөг	1,366,539.68	9.0%	1,184,301.91	8.0%	-182,237.77	-13.3%
Нийт дүн	15,108,609.35	100.0%	14,696,806.98	100.0%	-411,802.36	-2.7%

Тайлант улиралд ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөр 14,696,806.98 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 411,802.36 мянган төгрөг буюу 2.7 хувиар буурсан бөгөөд зах зээлийн нийт хөрөнгийн 5.5 хувийг эзэлж байна.

4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ 25,902,489.10 мянган төгрөг нь нийт эх үүсвэрийн 9.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 20: ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо		Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн		Нэг гишүүнд ногдох хувь хөрөнгө
			Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн
1	1,000,000.0 дээш	4	20,921	29.2%	12,771,069.47	49.3%	610.44
2	500,000.0-1,000,000.0	4	2,558	3.6%	2,692,431.34	10.4%	1,052.55
3	100,000.0-500,000.0	26	20,142	28.1%	5,625,319.38	21.7%	279.28
4	50,000.0-100,000.0	40	12,994	18.1%	2,598,175.89	10.0%	199.95
5	10,000.0-50,000.0	84	12,409	17.3%	1,971,900.34	7.6%	158.91
6	5,000.0-10,000.0	29	2,250	3.2%	214,554.21	0.9%	95.36
7	5,000.0 хүртэл	9	383	0.5%	29,038.46	0.1%	75.82
Нийт дүн		195	71,657	100.0%	25,902,489.10	100.0%	361.48

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө 100 сая төгрөгөөс дээш 34 ХЗХ

ХЗХ-ны зах зээлийн гишүүдийн оруулсан нийт хувь хөрөнгийн 81.4%

Нийт гишүүдийн 60.9%

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн өндөр 10 ХЗХ-ны мэдээллийг зах зээлийн нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээтэй харьцуулахад 63.1 хувийг эзэлж байна.

4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 59,776,318.70 мянган төгрөгт хүрч, нийт эх үүсвэрийн 22.3 хувийг эзэлж байна.

Тайлант улиралд 10 ХЗХ-ны нийт өр төлбөрийн хэмжээ нийт хөрөнгөөс хэтэрсэн буюу өөрийн хөрөнгөгүй болсон ба 8 ХЗХ нь “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан байна.

Хүснэгт 21: ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	7	34,563,177.04	57.8%
2	500,000.0-1,000,000.0	14	10,468,770.58	17.5%
3	100,000.0-500,000.0	51	10,574,221.07	17.7%
4	50,000.0-100,000.0	37	2,544,681.99	4.3%
5	10,000.0-50,000.0	63	1,799,564.57	3.0%
6	10,000.0 доош	14	91,136.89	0.1%
7	Өөрийн хөрөнгөгүй	10	-265,233.44	-0.4%
Нийт дүн		196	59,776,318.70	100%

Хүснэгт 22: ХЗХ-дын хоршоологчдын өмч, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	5	18,684,250.94	55.5%
2	500,000.0-1,000,000.0	7	4,299,830.65	12.8%
3	100,000.0-500,000.0	38	7,924,153.35	23.5%
4	50,000.0-100,000.0	22	1,531,056.93	4.5%
5	10,000.0-50,000.0	67	1,534,329.50	4.6%
6	5,000.0-10,000.0	15	107,003.56	0.3%
7	1,000.0-5,000.0	21	76,272.50	0.2%
8	1,000.0 хүртэл	2	1,061.06	0.0%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	19	-477,698.56	-1.4%
Нийт дүн		196	33,680,259.92	100.0%

Тайлант улиралд нийт 19 ХЗХ алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 ХЗХ буюу 11.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

5.1 ХЗХ-дын орлогын талаар

Тайлант улиралд зах зээлийн нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувь буюу 978,679.18 мянган төгрөгөөр нэмэгдэж 58,953,057.71 мянган төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 94.8 хувь хүүгийн орлого, 1.6 хувь үйл ажиллагааны

бусад орлого, 3.6 хувь үйл ажиллагааны бус орлого тус тус бүрдүүлж байна.

Зээлийн хүүгийн орлого 53,464,442.94 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 хувь буюу 2,659,863.59 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 23: ХЗХ-дын орлогын бүтэц (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны IV улирал		2022 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1. Хүүгийн орлого	54,215,900.41	93.5%	55,881,864.10	94.8%	1,665,963.69	3.1%
Зээлийн хүүгийн орлого	50,804,579.35	87.6%	53,464,442.94	90.7%	2,659,863.59	5.2%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	215,778.25	0.4%	276,803.63	0.5%	61,025.37	28.3%
Үнэт цаасны хүүгийн орлого	-	0.0%	9,800.00	0.0%	9,800.00	0.0%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	3,309,286.11	5.7%	2,461,902.00	4.2%	-847,384.11	-25.6%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	63,760.16	0.1%	11,793.10	0.0%	-51,967.07	-81.5%
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	177,503.46	0.3%	342,877.56	0.6%	165,374.10	93.2%
2. Үйл ажиллагааны бусад орлого	1,297,916.18	2.2%	949,072.77	1.6%	-348,843.41	-26.9%
3. Үйл ажиллагааны бус орлого	2,460,561.94	4.3%	2,122,120.83	3.6%	-338,441.10	-13.8%
Нийт орлого	57,974,378.53	100.0%	58,953,057.71	100.0%	978,679.18	1.7%

5.2 ХЗХ-дын зардлын талаар

ХЗХ-ны зах зээлийн нийт зардлын хэмжээ 47,336,684.58 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 хувь буюу 110,975.05 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд хүүгийн зардал 63.9 хувь, үйл ажиллагааны зардал 30.0 хувь, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 3.4 хувь, үйл ажиллагааны бус зардал 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүүгийн зардал 30,241,703.88 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3 хувь буюу 1,680,249.89 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 24: ХЗХ-дын зардлын бүтэц /мянган төгрөгөөр/


ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны IV улирал		2022 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1. Хүүгийн зардал	31,921,953.76	67.6%	30,241,703.88	63.9%	-1,680,249.89	-5.3%
Хадгаламжийн хүүгийн зардал	31,342,974.81	66.4%	29,452,790.65	62.2%	-1,890,184.16	-6.0%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	423,060.75	0.9%	786,691.80	1.7%	363,631.05	86.0%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	543.00	0.0%	0.00	0.0%	-543.00	-100.0%
Бусад хүүгийн зардал	182,961.80	0.4%	36,927.06	0.1%	-146,034.73	-79.8%
(Хүүгийн зардлын буцаалт)	27,586.60	0.1%	34,705.64	0.1%	7,119.04	25.8%
2. Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	1,975,028.75	4.2%	1,614,109.78	3.4%	-360,918.97	-18.3%
Зээлийн эрсдэлийн зардал	2,155,466.45	4.6%	1,672,373.83	3.5%	-483,092.62	-22.4%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	20,049.43	0.0%	0.00	0.0%	-20,049.43	-100.0%
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	200,487.13	0.4%	58,264.05	0.1%	-142,223.08	-70.9%
3. Үйл ажиллагааны зардал	12,199,119.75	25.8%	14,184,882.73	30.0%	1,985,762.98	16.3%
Боловсон хүчний зардал	7,682,721.37	16.3%	9,027,601.50	19.1%	1,344,880.13	17.5%
Бусад төрлийн зардал	4,516,398.38	9.5%	5,157,281.23	10.9%	640,882.85	14.2%
4. Үйл ажиллагааны бус зардал	262,479.44	0.6%	136,504.72	0.3%	-125,974.72	-48.0%
Татварын зардал	867,127.82	1.8%	1,159,483.47	2.4%	292,355.65	33.7%
Нийт зардал	47,225,709.53	100.0%	47,336,684.58	100.0%	110,975.05	0.2%
Цэвэр орлого	10,748,669.00	100.0%	11,616,373.13	100.0%	867,704.13	8.1%

5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт орлого 58,953,057.71 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувь буюу 978,679.18 мянган төгрөгөөр, нийт зардал 47,336,684.58 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 хувь буюу 110,975.05 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 11,616,373.13 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувь буюу 867,704.13 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт орлогын 80.3 хувийг зардал, 19.7 хувийг цэвэр орлого эзлэх бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогод эзлэх зардлын хувь хэмжээ 0.8 пунктээр буурч цэвэр орлогын эзлэх хувь нэмэгдсэн байна.

График 11: ХЗХ-дын ашигт ажиллагаа /хувиар/




Хүснэгт 25: ХЗХ-дын ашигт ажиллагаа /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны IV улирал	2022 оны IV улирал
Нийт орлого	57,974,378.53	58,953,057.71
Нийт зардал	47,225,709.53	47,336,684.58
Нийт орлогод эзлэх нийт зардлын хувь	81.5%	80.3%
Цэвэр орлого	10,748,669.00	11,616,373.13
Нийт орлогод эзлэх цэвэр орлогын хувь	18.5%	19.7%

ХЗХ-ны зах зээлийн нийт орлого сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

График 12: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/



ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХЗХ-дын 2022 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг тооцоход дараах байдалтай байна.

6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 26: ХЗХ-дын шалгуур үзүүлэлт хангасан байдал

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	135,163.01 мян.төг (34 ХЗХ) -61,314.08 мян.төг (14 ХЗХ)	48	24.5%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	29	14.8%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	15	7.7%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	1	0.5%
Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	51	26.0%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	8	4.1%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	22	11.2%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	28	14.3%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	2	1.0%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	34	17.3%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	45	23.0%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	25	12.8%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	25	12.8%
Зардлын зохистой хэмжээ				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	56	28.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	4%-аас доошгүй	39	19.9%
Өгөөж, зардлын хувь хэмжээ				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			4.3%

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ХЗХ-дын 17.3 хувь буюу 34 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 135,163.01 мянган төгрөгөөр илүү байгуулсан бол нийт ХЗХ-дын 7.1 хувь буюу 14 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 61,314.08 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна. Нийт ХЗХ-дын 14.8 хувь буюу 29 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 26.0 хувь буюу 51 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 11.2 хувь буюу 22 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 14.3 хувь буюу 28 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 17.3 хувь буюу 34 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 28.6 хувь буюу 56 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 19.9 хувь буюу 39 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын

зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

ХЗХ-ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 4.3 хувь байна.

Тайлант улиралд ХЗХ-дын 29.6 хувь буюу 58 ХЗХ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Хүснэгт 27: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	ХЗХ-дын тоо	Хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	58	29.6%
2	1 ЗХШҮ хангаагүй	45	22.9%
3	2 ЗХШҮ хангаагүй	34	17.3%
4	3 ЗХШҮ хангаагүй	16	8.2%
5	4 ЗХШҮ хангаагүй	16	8.2%
6	5 ЗХШҮ хангаагүй	27	13.8%
Нийт дүн		196	100.0%

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 196 ХЗХ хамрагдсанаас 6 ХЗХ-ны мэдээллийг өмнөх улирлын тайлангаар нэгтгэсэн болно.

- ХЗХ-дын статистик үзүүлэлт

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 196 ХЗХ 762 ажилтан, 71,657 гишүүн /71,438 иргэн, 219 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт 196 ХЗХ-ны 29.1 хувь буюу 57 ХЗХ төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх, 2.6 хувь буюу 5 ХЗХ санхүүгийн түрээсийн үйлчилгээ, 2.6 хувь буюу 5 ХЗХ даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа, 0.5 хувь буюу 1 ХЗХ мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байв. Төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй 57 ХЗХ-ны 3 ХЗХ нь орон нутгийн, 54 нь “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан Улаанбаатар хотын ХЗХ-д байна. “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд шинээр байгуулагдсан ХЗХ-дын 30.6 хувь буюу 15 ХЗХ төслийн зээлийн үлдэгдлийг бүрэн төлж дууссан байна.

Улсын Их Хурлаас 2022.06.17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталж, 2023.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх болсонтой холбогдуулан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг тус хуульд нийцүүлэн Хорооны 2022.12.09-ний өдрийн 687 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Үүнтэй холбогдуулан Хорооны 2022 оны 723 дугаар тогтоолоор нэр бүхий 54 ХЗХ-ны, Хорооны даргын 2022 оны 543 дугаар тушаалаар нэр бүхий 9 ХЗХ-ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох тухай асуудлыг шийдвэрлэсэн тул 2023.01.01-ний өдрөөс ХЗХ-д зөвхөн хадгаламж болон зээлийн үйл ажиллагааг эрхлэх юм.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 5.0 хувь буюу 3,743 гишүүнээр буурч 71,657 гишүүнтэй болсон байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн тоо 39,626 буюу нийт гишүүдийн 55.3 хувь, орон нутгийн ХЗХ-дын гишүүдийн тоо 32,031 буюу нийт гишүүдийн 44.7 хувийг эзэлж байна.

Нийт ХЗХ-дын 50.0 хувь буюу 98 ХЗХ санхүүгийн програм хангамжтай бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 ХЗХ буюу 4.3 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант улиралд ХЗХ-дын 7.7 хувь буюу 15 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 40,049,376.97 мянган төгрөгийн 349 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 88.5 хувь буюу 24,210,731.55 мянган төгрөгийн гүйлгээг Улаанбаатар хотын 11 ХЗХ, 26.7 хувь буюу 15,838,645.42 мянган төгрөг бүхий 40 гүйлгээг орон нутгийн 4 ХЗХ мэдээлсэн байна. Тайлант улирлын байдлаар сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

- Зах зээлийн санхүүгийн үзүүлэлт

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 267,715,699.75 мянган төгрөг нь банкны зах зээлийн 0.6 хувь, нийт зээл 210,229,235.80 мянган төгрөг нь банкны зах зээлийн 0.9 хувь, чанаргүй зээл 7,046,472.75 мянган төгрөг нь банкны зах зээлийн 0.4 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 187,500,577.22 мянган төгрөг нь банкны зах зээлийн 1.1 хувийг тус тус эзэлж байна.

ХЗХ-дын гишүүдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 25,902,489.10 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 9.6 хувь,

хоршоологчдын өмч 33,680,259.92 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 12.6 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд зах зээлийн хэмжээнд 58,953,057.71 мянган төгрөгийн орлого, 47,336,684.58 мянган төгрөгийн зардал, 11,616,373.13 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна. Цэвэр орлогын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 8.1 хувь буюу 867,704.13 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2022 оны 4 дүгээр улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хөрөнгө 8.1 хувь буюу 23,481,763.70 мянган төгрөгөөр, нийт хадгаламжийн хэмжээ 7.9 хувь буюу 16,085,333.96 мянган төгрөгөөр, нийт зээлийн үлдэгдэл 1.5 хувь буюу 3,192,232.73 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

- Орлого, зарлага

Тайлант хугацаанд ХЗХ-ны зах зээлийн нийт орлогын 94.8 хувь буюу 55,881,864.10 мянган төгрөгийг хүүгийн орлого, 1.6 хувь буюу 949,072.77 мянган төгрөгийг үйл ажиллагааны бусад орлого, 3.6 хувь буюу 2,122,120.83 мянган төгрөгийг үйл ажиллагааны бус орлого, нийт зардлын 63.9 хувь буюу 30,241,703.88 мянган төгрөгийг хүүгийн зардал, 30.0 хувь буюу 14,184,882.73 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардал тус тус бүрдүүлж байна. ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд цэвэр орлого 11,616,373.13 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувь буюу 867,704.13 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт бөгөөд ХЗХ-дын 13.8 хувь буюу 27 ХЗХ нь 1,138,248.66 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Тайлант хугацаанд зах зээлийн хэмжээнд Хорооноос тогтоосон зайлшгүй хангах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ХЗХ-дын 29.6 хувь буюу 58 ХЗХ бүрэн

хангаж ажилласан бөгөөд нийт ХЗХ-дын 14.8 хувь буюу 29 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 26.0 хувь буюу 51 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 11.2 хувь буюу 22 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 14.3 хувь буюу 28 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 17.3 хувь буюу 34 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 28.6 хувь буюу 56 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 19.9 хувь буюу 39 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. ХЗХ-ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 4.3 хувь байна.

- Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлт

2021 оны 4 улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 209 ХЗХ-оос тайлант улирлын байдлаар нэр бүхий 20 ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 2022 оны 1 дүгээр улиралд 3 ХЗХ, 2 дугаар улиралд 2 ХЗХ, 3 дугаар улиралд 2 ХЗХ-нд тус тус хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. 2022 онд аудитын тайланг баталгаажуулж ирүүлэх 189 ХЗХ-ны 96.8 хувь буюу 183 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэн Хороонд ирүүлсэн байна. Харин Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасны дагуу бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж, бүх гишүүдийн хурлын материалыг ирүүлэх 189 ХЗХ-ны 98.9 хувь буюу 187 ХЗХ холбогдох материалыг Хороонд ирүүлсэн байна.

2022 оны 4 дүгээр улиралд нийт ХЗХ-дын 7.7 хувь буюу 15 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 40,049,376.97 мянган төгрөгийн 349 гүйлгээг мэдээлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын ХЗХ-дын 48.6 хувь буюу 52 ХЗХ, орон нутгийн ХЗХ-дын 48.3 хувь буюу 43 ХЗХ Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК болон “Бүрэн скор ЗМС” ХХК-тай мэдээлэл өгөх, авах гэрээг тус тус байгуулсан байна.